



ДӨРВӨН УУЛ ХК

ДӨРВӨН УУЛ ХК-ИЙН 2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна.

2021 оны эхний хагас жилд манай компани амжилтаа ахиулсан жил байсныг цохон тэмдэглэхэд таатай байна.

Манай компани 2021 онд 1 ажлын байр түрээслэгч байгууллага, 20 худалдан авагч байгууллагатай, 6 ажиллагсадтай, 5 нэр төрлийн хөзөр, Германы Varta брэндийн бүх төрлийн баттерей борлуулах үйл ажиллагаа явууллаа.

Одоо та бүхэнд 2021 онд тус компанийн хийж гүйцэтгэсэн ажлыг үйл ажиллагааны чиглэл тус бүрээр товч танилцуулъя.

Нэг : Санхүүгийн чиглэлээр :

“Дөрвөн Уул” ХК нь 2021 онд санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тогтоосон хугацаанд гаргаж, санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулан харьяа татварын албаар хянуулж, зохих байгууллагуудад хүргүүлэн МУ-ын хууль тогтоомжийг мөрдөн ажиллалаа. Өөрийн гэсэн орлоготой болж үйл ажиллагаа тогтмолжих, өргөжих төлөвтэй болсон зэрэг дэвшилт гарсан болно.

Хоёр: Борлуулалтын чиглэлээр :

1. Манай компани нь 2018 оноос. Сүлжээ дэлгүүрүүдэд хөзөр борлуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. ДӨРВӨН УУЛ ХК-нь хөзөр борлуулалтын 20 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж байна. Энэ нь өмнөх оны сүүлээс 8 нэгжээр нэмэгдүүлсэн бөгөөд 2021 оны хагас жилийн хөзөр борлуулалтын орлого 74771,6 мянган төгрөг болж өссөн.
2. Ажлын байр түрээсийн 1 ААН-тэй хамтран ажиллаж түрээсийн орлого 12167,6 байна.

Гурав: Хүний нөөцийн чиглэлээр :

“Дөрвөн Уул” ХК нь хүний нөөцийн хувьд тогтвортой ажилтан, албан хаагчидтай

болж байнгийн 6 ажилтантай ажиллаж байна.

Дөрөв: 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт

4.1 Борлуулалтын нэгжийг 8-р нэмэгдүүлсэн

4.2 Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас Германы Varta брэндийн бүх төрлийн баттерейг авч борлуулах гэрээг амжилттай хийсэн.

**Анхаарал тавьсан “ДӨРВӨН УУЛ ” ХК-ийн хүндэт хувьцаа эзэмшигч
ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА.**